



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 36 (369)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:

- *Уртын дуугаа өвлөн дэлгэрүүлэх тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2004 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2004 оны есдүгээр сарын 20

№ 36 (369)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:

361.	Дайзо Нозаваг "Алтан гадас" одонгоор шагнах тухай	Дугаар 132	699
362.	Кенжиро Каваматаг "Найрамдал" медалиар шагнах тухай	Дугаар 133	699
363.	Уртын дуугаа өвлөн дэлгэрүүлэх тухай	Дугаар 134	699
364.	Анатолий Степанович Кореневыг "Найрамдал" медалиар шагнах тухай	Дугаар 135	700

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

365.	Хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай	Дугаар 157	701
------	--	------------	-----



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр

Дугаар 132

Улаанбаатар хот

Дайзо Нозаваг “Алтан гадас” одонгоор шагнах тухай

Монгол Улс, Япон Улсын найрсаг харилцаа, парламент хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Япон Улсын

Хууль зүйн сайд Дайзо Нозаваг “Алтан гадас” одонгоор шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр

Дугаар 133

Улаанбаатар хот

Кенжиро Каваматаг “Найрамдал” медалиар шагнах тухай

Монгол Улс, Япон Улсын парламент хоорондын хамтын ажиллагаа, төрийн бус байгууллагуудын харилцааг өргөжүүлэн хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Япон-Монголын эв найрамдлын

нийгэмлэгийн ерөнхий нарийн бичгийн дарга Кенжиро Каваматаг “Найрамдал” медалиар шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр

Дугаар 134

Улаанбаатар хот

Уртын дуугаа өвлөн дэлгэрүүлэх тухай

Монгол ардын уртын дуу бол монгол үндэстний буурал түүх, малчин ахуй, амьдралын гүнээс өөрөө урган гарч, монгол нутгийн байгалийн үзэсгэлэн, монгол хүний уужуу тайван сэтгэлийн зохилдлого, нүүдэлчдийн аж төрөхүй, зан заншлын өвөрмөц уянга болон төгөлдөржиж, цараа тавиун хөг аялгуу, төв эрхэмсэг намба, уран

гоё нугалаа, баян чимэг бүхий шуранхай, хөг эгшгийн өвөрмөц онцлогтойн хувьд аливаа ард түмний дуунд үл давтагдах ховор шинж агуулсан ардын дууны урлагийн хосгүй уламжлалт сонгодог өв мөн.

Монгол соёл иргэншлийн онцгой ололт, агуулга, хэлбэр, ая хөг, үг хэллэг, айзам хэм төгөлдөрийн хувьд монгол соёлын



өвөрмөц ололт болсон уртын дууны баян өв санг хадгалах, төрийн хамгаалалтад байлгах, дээдлэн дэлгэрүүлэх талаар төрийн болон төрийн бус байгууллага, эрдэмтэд, иргэдээс удаа дараа гаргасан санал, хүсэлтийг дэмжин, Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх заалтын 3, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 12 дугаар зүйлийн 12 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ буулгах нь:

1.Монгол ардын уртын дууг залуу үед өвлүүлэн эзэмшүүлэх, дуулах эрдэмд сургаж, бүх нийтээр үндэсний бахархлын зэрэглэлээр дээдлэн дэлгэрүүлж, монгол үндэстэн, монгол хүний нэрийн хуудас, төр ёс, баяр цэнгэл, хэв заншлын журамт шинж болгох өргөн олны хөдөлгөөн өрнүүлэхийг

нийт ард иргэд, аймаг, нийслэлийн төрийн болон төрийн бус байгууллага, соёл урлагийн ажилтан, зүтгэлтэн, эцэг эх, багш нар уриалсугай.

2.Уртын дууг сурвалжлан олох, сургаж эзэмшүүлэх, судлан шинжлэх, сурталчлаж даяаршуулах цогц асуудлыг тусгасан хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхийг Засгийн газарт чиглэл болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Ц.ЭЛБЭГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 9 дүгээр сарын 3-ны өдөр

Дугаар 135

Улаанбаатар хот

**Анатолий Степанович Кореневыг
“Найрамдал” медалиар шагнах тухай**

Монгол Улс, ОХУ-ын төмөр замын хамтын ажиллагааг бэхжүүлэх, монголын төмөр замыг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Хувь нийлүүлсэн “УБТЗ”-ын Ерөнхий хорооны гишүүн, Дорнод Сибирийн төмөр замын Улаан-Үүд тасгийн

дарга Анатолий Степанович Кореневыг “Найрамдал” медалиар шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**



2004 оны 7 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар 157

Улаанбаатар
хот

Хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай

Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 6.3, 18.1.1, 19.1.1 дүгээр заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

стандартыг шаардлагатай тохиолдолд мөрдүүлэх арга хэмжээ авахыг стандартчиллын асуудал эрхэлсэн сайд болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт зөвшөөрсүгэй.

Нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдлыг хамгаалах объектод тогтоосон заавал мөрдөх үндэсний стандартаас бусад сонгон хэрэглэх үндэсний

Монгол Улсын

Ерөнхий сайд

Н.ЭНХБАЯР

Үйлдвэр, худалдааны

сайд

Ч.ГАНЗОРИГ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
"Төрийн Мэдээлэл" эмхтгэлийн зөвлөл
Улаанбаатар- 12,
Төрийн ордон
☎ 329612

Индекс 14063

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487

Хэвлэлийн хуудас 0 5